

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Х.ХЭРЛЭНТЭЙ
БАЙГУУЛАХ ХӨЛСӨӨР АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2016 оны 10 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас: “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Р.Мэргэн,

Нөгөө талаас: “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Хишигжаргалын Хэрлэн, оршин суух хаяг: Улаанбаатар хот, нар (цаашид дангаар нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 1/295 тоот удирдамж, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 16 дугаар тогтоолыг үндэслэн энэхүү гэрээг дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Компанийн хөрөнгийг үр ашигтай эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж компанийн эдийн засгийн эерэг үзүүлэлтийг нэмэгдүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2. Гүйцэтгэх захирал үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль, тогтоомж, Компанийн дүрэм, энэхүү гэрээ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг удирдлага болгон ажиллана.
- 1.3. Гүйцэтгэх захирал нь ажил, үүргээ Компанийн дүрэм болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй, бусад аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхгүй байж, гэрээний үүргийн биелэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө биечлэн хариуцна.
- 1.4. Гэрээ хүчинтэй байх хугацааны, эрх бүхий этгээдийн баталсан Компанийн зорилтот түвшин он тус бүрээр энэ гэрээний хавсралт болох бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг

- 2.1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн нийт төгрөгийн актив хөрөнгө /2016 оны 2 дугаар улирлын байдлаар/-ийг Гүйцэтгэх захирлыг томилогдсон даруй зохих журмын дагуу хүлээлгэн өгнө.

Жил бүр, жилийн эцсийн тайлан тэнцлийн дүнгээр хөрөнгийг баталгаажуулж, гэрээний сунгалтад тусгана.

- 2.2. Гүйцэтгэх захиралд олгох цалин хөлс, урамшууллыг энэхүү гэрээний 6 дугаар зүйлд заасан нөхцөлийн дагуу олгоно.
- 2.3. Энэ гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхтэй холбогдуулан Гүйцэтгэх захирлын тавьсан санал, хүсэлтийг цаг тухайд нь хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2.4. Гүйцэтгэх захирлыг хууль болон энэхүү гэрээг зөрчсөн буруутай үйл ажиллагаа явуулсан гэж үзвэл Төлөөлөн удирдах зөвлөл /гишүүн/ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдэгдэнэ.
- 2.5. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан хэлэлцэж, дүгнэлт гарган цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулна.

Холбогдох баримт бичгийг Гүйцэтгэх захиралд олгох урамшуулал (хүлээлгэх хариуцлага)-ын талаарх саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд оруулж, шийдвэрлүүлнэ.

- 2.6. Компанийн хэрэгжүүлж байгаа төслийн техник эдийн засгийн үндэслэлийг үндэслэн уг төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтэц, орон тоог хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох эрх бүхий дээд байгууллагуудтай зөвшилцөж батална /Тухайн жилд төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр “Төсөл хэрэгжүүлэгч”-ээр ажиллах болсон аливаа төсөл хамаарна/.
- 2.7. Гүйцэтгэх захирал Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний үүргээ биелүүлэх явцад халдлагад өртөх, нэр төрөө гутаалгах, шахалт дарамтад орох тохиолдолд түүний хүсэлтээр зохих арга хэмжээг эрх хэмжээнийхээ хүрээнд авч хэрэгжүүлнэ.

Гурав. Гүйцэтгэх захирлын үүрэг

- 3.1. Гүйцэтгэх захирал нь энэхүү гэрээний хавсралт дахь Компанийн зорилтот түвшний үзүүлэлт нэг бүрийг ханган биелүүлж, компанийн ашиг, орлогыг нэмэгдүүлэх үндсэн үүрэг хүлээнэ.
- 3.2. Хууль тогтоомж, Компанийн дүрэм, энэ гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дагуу компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Компанийн удирдлагын болон аж ахуйн менежментийг боловсронгуй болгох, технологийн шинэчлэл хийх, үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэх зэрэгт анхаарч, бодитой үр дүнд хүрч ажиллана.

- 3.3. Компанийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх саналын төслийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу боловсруулж, мөн зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.
- 3.4. Энэ гэрээний 3.3-т дурдсан саналын талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хуулийн хугацаанд эцэслэн тохирох бөгөөд түүнд үндэслэн боловсруулсан дараа жилийн үйл ажиллагааны зорилтот түвшний саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж саналыг тусган, тухайн оны 04 дүгээр сарын 20-ны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд оруулж, батлуулах арга хэмжээ авна.
- 3.5. Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд дараа жилийн 03 дугаар сарын 01-ний дотор аудитын дүгнэлт хийлгэх бөгөөд ийнхүү дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор тайланг аудитын дүгнэлтийн хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.
- 3.6. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан, энэ гэрээний биелэлтийн тайлан тус бүрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараа оны эхний улиралд багтаан хэлэлцүүлнэ.
- 3.7. Дараах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр шийдвэрлэнэ.
 - 3.7.1. Эрхлэх бизнесийн үндсэн төрөл, чиглэлээс өөр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах;
 - 3.7.2. Ажиллагсдын нийгэм, хангамжийн шинжтэй хөрөнгө оруулалт хийх (Хөдөлмөрийн дотоод журамд заасан асуудал хамаарахгүй);
 - 3.7.3. Компанийн хөрөнгийг данснаас хасах, захиалах, шинээр авах, устгах, актлах;
 - 3.7.4. Бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах;
 - 3.7.5. Бусад этгээдэд компанийн барилга, байгууламжийг түрээслүүлэх;
Түрээслүүлсэн барилга, байгууламжид нийт хөрөнгийн /үнийн дүнгийн 10/ хувиас дээш хэмжээтэй хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл олгохдоо Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан журмыг баримтална.
 - 3.7.6. Компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зардлын төсөв батлах;
 - 3.7.7. Компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг томилох, ажлаас халах, чөлөөлөхтэй холбоотой ажил олгогчийн шийдвэр гаргах;
 - 3.7.8. Сонирхолын зөрчилтэй гэрээ, хэлцэл хийх;
 - 3.7.9. Их хэмжээний гэрээ, хэлцэл хийх, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 3.7.10. Компанийн бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй, хэрэгцээнээс илүү хэмжээний үндсэн ба туслах материал, үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдолгүй (үүнд

компанийн хэрэгжүүлж байгаа бүх төсөл, хөтөлбөрийг ойлгох) бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар гадаад, дотоодын иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ, хэлцэл хийх;

3.7.11. Компанийн үйл ажиллагааны зориулалтаар банкнаас зээл авах.

- 3.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр компанийн эд хөрөнгөөс зээл олгох, хандивлах, бэлэг өгөх, бусдад хөрөнгийн баталгаа гаргахыг хориглоно.
- 3.9. Холбогдох журмын дагуу Хувьцаа эзэмшигчид олгох ногдол ашгийн тооцооны саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 3.10. Хувьцаа эзэмшигчид олгох ногдол ашгийн хэмжээг тогтоох, түүнийг олгох тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 1 сарын дотор төрийн өмчид ногдох ногдол ашгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дансанд төвлөрүүлнэ.

Энэ тухай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тухай бүр мэдээлнэ.

- 3.11. Компанийн бизнесийн нууцад хамаарах мэдээлэл, баримт бичгийн нууцын зэрэглэлийг тогтоож, нууцлалыг хадгалах, хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, хяналтыг хэрэгжүүлнэ.
- 3.12. Компанийн өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих өдөр тутмын дотоод хяналтыг удирдан зохион байгуулж, үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө хариуцна.
- 3.13. Компанийн эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль заасан журмын дагуу хийж хагас, бүтэн жилийн тайлан тэнцэлд тусгана.
- 3.14. Компанийн санхүүгийн тайлан тэнцлийг хуульд заасан журмын дагуу гаргах ажлыг зохион байгуулж Төлөөлөн удирдах зөвлөлд оруулж хэлэлцүүлэн тайлангийн нэг хувийг дараа сарын 25-ны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж баталгаажуулна.
- 3.15. Компанийн тухай хуулийн 99.1-д хамаарагдах нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран ажиллаж байгаа бол энэ тухайгаа Төлөөлөн удирдах зөвлөлд мэдэгдэнэ.
- 3.16. Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн чиглэл, үүрэг, даалгаврын биелэлтийг тогтоосон хугацаанд бичгээр танилцуулна.
- 3.17. Гүйцэтгэх захирлын албан томилолтын удирдамж, төсвийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар батлуулна.
Салбарын сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын тушаал, удирдамжийн дагуу албан томилолтоор ажиллах бол томилолтын төсвийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга батална.
- 3.18. Холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэмд заасан гүйцэтгэх удирдлагын үүргийг хэрэгжүүлж ажиллана.

Дөрөв.Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх

- 4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай танилцах, шалгах, зөвлөх, эрхтэй бөгөөд өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг тогтоол, тэмдэглэл хэлбэрээр, бичгээр гаргана.
- 4.2. Гүйцэтгэх захирын буруутай үйл ажиллагааны улмаас компанид хохирол учирсан бол хохирлыг барагдуулахаар хуулийн байгууллагад зохих журмын дагуу хандах эрхтэй.
- 4.3. Компанийн болон Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх өөрийн төлөөлөгчийг тодорхой хугацаагаар хэдийд ч томилон ажиллуулж болно.
- 4.4. Улирал бүр, шаардлагатай бол тухай бүр компанийн бизнесийн үйл ажиллагааны талаар Гүйцэтгэх захирлын мэдээллийг сонсоно.
- 4.5. Компанийн тайлан тэнцэл, мэдээ, судалгаанд үндэслэн менежментийн бодлого, үйлдвэрлэл, технологи, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр шинжлэн дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.
- 4.6. Шаардлагатай бол компанийн удирдлага, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд холбогдох яам, төрийн байгууллагуудтай хамтран мэргэжлийн хүмүүсийг оролцуулан хяналт, шалгалт хийж болно.
- 4.7. Гүйцэтгэх захирал 30-аас дээш хоногийн хугацаанд эзэнгүй байх /энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүй нөхцлийг ойлгоно/ тохиолдолд Гүйцэтгэх захиралтай зөвшилцөн үүрэг гүйцэтгэгчийг томилж, эрх, үүргийн хэмжээг тогтооно.

Тав.Гүйцэтгэх захирлын эрх

- 5.1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний дотор компанийн хөрөнгийг захиран зарцуулна.
- 5.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэхээс бусад асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд гэрээ, хэлцэл байгуулна.
Үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагаа, техник, технологит осол аваарь гарч онцгой нөхцөл байдал үүссэн үед зайлшгүй шаардлагатай сэлбэг, материалыг худалдан авах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэнэ.
- 5.3. Шаардлагатай асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулахаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд тухай бүр санал гаргах эрхтэй.
- 5.4. Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх, хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 5.5. Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, тогтоомжид нийцүүлэн компанийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх тушаал, заавар, журам, эрх зүйн бусад актыг гаргана.

Зургаа. Цалин хөлс, урамшуулал, ажлын нөхцөл

- 6.1. Гүйцэтгэх захирлын үндсэн цалинг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн баталсан “Цалингийн сүлжээ”-ний шатлалаар тооцон сар бүр олгоно.
- 6.2. Гэрээний хавсралт дахь Компанийн зорилтот түвшний биелэлт, компанийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр ашигт байдал, эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хууль тогтоомжийн хэрэгжилт, дараа оны ажлын бэлтгэл зэргийг харгалзан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан журмын дагуу урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.3. Гүйцэтгэх захирлын ажил, амралтын цаг, ээлжийн амралтыг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна.

Ээлжийн амралтын хуваарь гаргах, биеэр эдлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад бичгээр урьдчилан мэдэгдэж, зөвшилцөнө.
- 6.4. Албан үүргээ гүйцэтгэх ажлын өрөө, тавилга хэрэгсэл, ажлын хэрэгцээний суудлын автомашин, харилцаа холбоо /суурин ба үүрэн телефон/-ны болон бусад техник хэрэгслээр хангана.

Үүрэн телефон хэрэглэх зардал, суудлын автомашины гүйлтийн хэмжээг Засгийн газар, холбогдох эрх бүхий байгууллагаас тогтоосон нормыг баримтлан тогтооно.

Гүйцэтгэх захирал ээлжийн амралтаа биеэр эдлэх хугацаанд албаны суудлын автомашин, үүрэн телефоныг жилийн нормоос хэтрүүлэлгүй ашиглах эрхтэй.
- 6.5. Гүйцэтгэх захирал албан үүргээ гүйцэтгэж байгаад хөдөлмөрийн чадвараа 6 ба түүнээс дээш сар алдсан бол Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр 6 хүртэл сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нөхөн олговор олгож болно.
- 6.6. Гүйцэтгэх захиралд олгох нэмэгдэл, тэтгэмж, тусламж, нөхөн төлбөртэй холбоотой харилцааг Хөдөлмөрийн тухай хууль болон Компанийн хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

Долоо. Хариуцлага

- 7.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль, тогтоомж, Компанийн дүрэм, энэ гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 7.2. Гүйцэтгэх захирал холбогдох хууль тогтоомж Компанийн дүрэм, энэ гэрээгээр өөрт олгогдсон эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашигласны улмаас компанид хохирол учруулсан бол өөрийн хувийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

Найм. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах

- 8.1. Талууд харилцан тохиролцож хэдийд ч гэрээг цуцалж болно.

Гэрээний хүчинтэй хугацаанд гэрээний нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээ дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно:

- 8.2.1. Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон;
 - 8.2.2. Талууд харилцан тохирсон;
 - 8.2.3. Хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага шаардсан;
 - 8.2.4. Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан;
 - 8.2.5. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.
- 8.3. Дараах тохиолдолд Гүйцэтгэх захирлын санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцална:
- 8.3.1. Эрүүл мэндийн шалтгааны улмаас ажил, үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсон;
 - 8.3.2. Хүндэтгэх үзэх бусад шалтгаан бий болсон.
- 8.4. Дараах тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлийн санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцална:
- 8.4.1. Хувьцаа эзэмшигчээс гэрээг цуцлах талаар удирдамж, чиглэл өгсөн;
 - 8.4.2. Гүйцэтгэх захирлын гэрээний үүргийн биелэлт хангалтгүй үнэлэгдсэн;
 - 8.4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй ажил олгогчийн буруутай үйлдлийн улмаас үйлдвэрлэл, үйлчилгээнд ноцтой осол, аваарь гарсан бол;
 - 8.4.4. Гүйцэтгэх захирлын шийдвэр, буруутай үйл ажиллагааны улмаас компанид хохирол учирсан, компани санхүүгийн алдагдалд орсон;
 - 8.4.5. Гүйцэтгэх захирал хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хууль тогтоомж, харъяа дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хэрэгжүүлээгүй, биелүүлээгүй, зөрчсөн, компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргээ зохих ёсоор биелүүлээгүй;
 - 8.4.6. Гүйцэтгэх захирал өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй шалтгаан нөхцлүүд бий болсон;
 - 8.4.7. Гүйцэтгэх захирал 6 сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан;
 - 8.4.8. Компани татан буугдсан, дампуурсан, төрийн мэдлийн бүх хувьцааг бусад өмчийн этгээдэд худалдсан;
 - 8.4.9. Хуульд заасан бусад үндэслэл;
- 8.5. Энэ гэрээ дуусгавар болсон тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл өмч хөрөнгийн эзэмшилт, ашиглалтын байдлыг тогтоож, компанийн эд хөрөнгийн тооллого хийж, дараагийн Гүйцэтгэх захиралд ажлыг хүлээлцүүлнэ.
- 8.6. Гэрээг хугацаанаас өмнө цуцалсантай холбогдуулан Гүйцэтгэх захиралд тэтгэмж олгох эсэх асуудлыг Хөдөлмөрийн тухай хуульд заасныг баримтлан Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

Ес. Гэрээний хугацаа, гэрээг дүгнэх

- 9.1. Энэхүү гэрээ нь Гүйцэтгэх захиралтай “Хөлсөөр ажиллах гэрээ” байгуулах тухай “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 16 дугаар тогтоол гарсан өдрөөс эхлэн 1 /нэг/ жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 9.2. Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээний биелэлтийг дүгнэнэ.
Төлөөлөн удирдах зөвлөл уг дүгнэлтийг үндэслэн гэрээг сунгах эсэхийг шийдвэрлэж, сунгах тохиолдолд хугацааг тогтоож, энэ тухай тэмдэглэл үйлдэн, гэрээнд хавсаргана.
- 9.3. Гэрээний 9.2-т заасан шийдвэр гарахаас өмнө гэрээний үндсэн хугацаа дууссан тохиолдолд гэрээг тодорхойгүй түр хугацаагаар сунгасанд тооцно. Энэ хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл гэрээг хэдийд ч шууд цуцлах эрхтэй байна.

Арав. Бусад

- 10.1. Гүйцэтгэх захирал өмчийн аливаа хэлбэрийн бусад хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлтэй урьдчилан зөвшилцөнө.
- 10.2. Талуудын гарын үсгээр баталгаажсан гэрээний эх хувиуд адил хүчинтэй.
Бичгээр үйлдэж, Талуудын гарын үсгээр баталгаажсан гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээний нэгэн адил хүчинтэй байна.
- 10.3. Талуудын хооронд үүссэн маргааныг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 10.4. Гэрээг 3 хувь үйлдэж, Талууд болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА

...../Р.МЭРГЭН/

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

...../Х.ХЭРЛЭН/